



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/69/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2020 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: Утас: 88011833 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn Аудитор: Г.Ганчимэг Утас:88268424 Цахим хаяг: ganaa_7133@yahoo.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.13. Шилэн дансны мэдээлэл	10
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	11
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
Менежментийн захидал	12
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	15
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	17
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	19
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	21
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	21
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	23

Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Ц.НАСАНБАЯР ТАНАА 7

Бодо.Од.14 № 1/87

танай _____ -ны № _____ -т

Г _____ 7

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020046

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

Аудитын тайлан

2.1. Оршил

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Ц.Насанбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.08-аас 2020.02.10-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.14-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Г.Ганчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газар-т 2020.01.24-ний өдөр, аудит хийлгэх хүсэлтээ 2020.01.06-ний өдрийн 3/05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Өндөр мэдлэг, ур чадвартай зарчимч мэргэшсэн, төрийн албан хаагчдыг үр дүнтэй, тогтвортой ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлж, сумын удирдлагад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, сумын нийгэм эдийн засгийн хөгжлийн бодит нөхцөлд шинжилгээ хийж, иргэддээ үйлчлэхэд оршино”.

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Нийгмийн олон талт цогц үйлчилгээ хүргэн, Төрийн удирдлагыг нээлттэй, ил тод, шуурхай байлгаж, Эрх зүйн сургалт, сурталчилгааг тогтмолжуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэн, Гадаад орны болон бусад аймгийн ижил төрлийн байгууллагуудтай тогтоосон хамтын ажиллагааг сум /хот/-ын хөгжил рүү чиглүүлж, Төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадвар, туршлагыг дээшлүүлэн хүний нөөцийн хөгжлийг хангах зэрэг болно.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлого нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acolous” программ хангамж ашиглаж байна.

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 39 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 33 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1510914,1 мянган төгрөгөөс тооцон 15109,1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 1 тэрбумаас дээш тул 1% буюу 15109,1 мянган төгрөгөөр тооцсон нь үр дүнгийн тайлангийн зардлыг суурь болгон сонгосонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9321,3 мянган төгрөгөөр буюу 0,7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	164.90		(164.90)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	74,468.50	82,978.90	8,510.40
Үндсэн хөрөнгө	1,454,048.20	1,533,325.00	79,276.80
Хуримтлагдсан элэгдэл	(277,024.00)	(360,816.20)	(83,792.20)
Нийт хөрөнгө	1,251,657.60	1,255,487.70	3,830.10
Өр төлбөр	2,254.90		(2,254.90)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,249,402.70	1,255,487.70	6,085.00
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,251,657.60	1,255,487.70	3,830.10

Авлага дансны үлдэгдэлд өмнөх оноос 164,9 мянган төгрөгөөр хасагдаж тайлант онд авлага үүсээгүй

Бараа материалын дансны үлдэгдэл 8510,3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр аж ахуйн болон сэлбэг, бичиг хэргийн материал худалдан авч бэлтгэснээс

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 79276,0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 11627,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 6272,0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан, ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 24259,6 мянган төгрөгийн хашаалсан талбай, АИТХ-ын 2019 оны 09 дүгээр сарын 23 ний өдрийн 17/12 тоот

тогтоолоор “Супрессор” өрхийн Эрүүл мэндийн төвийн барилга 27624,2 мянган төгрөг, 11928,0 мянган төгрөгийн газар тус тус үнэ төлбөргүй шилжиж ирснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данснаас АИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 25 ний өдрийн 1129 тогтоолоор 2434,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж акталж данснаас хассан.

Биет бус хөрөнгийн данс 11928,0 мянган төгрөгөөр өссөн нь “Супрессор” өрхийн Эрүүл мэндийн төвийн эзэмшлийн 11928,0 мянган төгрөгийн газар үнэ төлбөргүй шилжиж ирснээс шалтгаалжээ, биет бус хөрөнгийн хасагдуулга данс нь 300,0 мянган төгрөгөөр буюу тайлант оны хасагдуулгаар өссөн байна.

Өр төлбөрийн данс нь өмнөх оны өглөгийг бүр барагдуулсан бөгөөд тайлант өр төлбөр үүсээгүй.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1255487,7 мянган төгрөг болж 6085,0 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлт нь тайлант үеийн үр дүнгийн зардал байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга гараагүй дахин үнэлгээний дансанд өөрчлөлт ороогүй байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд үндсэн үйл ажиллагаанаас 1100,0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 150,0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 13,6 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мал аж ахуйн орлого	1100,0	150,0	950	13,6
Нийт дүн	1100,0	150,0	950	13,6

Өөрийн орлого 950,0 мянган төгрөгөөр тасарсан нь тус байгууллагын гэрээт малчин Ю.Цэрэн-давга-д 100,0 мянган төгрөгөөр урамшуулал олгож байгаа нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур цалин хөлс олгосон гэж аймгийн Мэргэжлийн хяналтын газраас зөрчлийг арилгах албан шаардлага ирүүлсний дагуу малчинд урамшуулал олгохгүй, 2019 оны малын түүхий эдийн орлого 22,5 кг ноолуурыг олгохоор гэрээ байгуулж ажилласнаас орлогын төлөвлөгөө тасарсан.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 6 зориулалтад 1383342,5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 510275,0 мянган төгрөгийг “Цэвэр хот” ОНӨХХК-ын санхүүжилтэд, 873067,5 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1382242,5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 1100,0 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1382351,0 мянган төгрөг буюу 99,9 хувьтай байгаа нь өөрийн орлогын төлөвлөгөө 950,0 мянган төгрөгийн орлогыг тасарснаас шалтгаалжээ.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсөв захирагчаас буюу аймгийн ЗДТГ-аас шагналын зардал 5,0 сая, аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газраас оготно устгалын зардал 7,2 сая, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас хүүхэд хамгааллын зардал 4,5 сая, өсвөрийн шатрын тэмцээний зардал 540,0, Шинжлэх ухаан технологийн Их сургуулиас "Инновац"-ийн төвийн байрны цахилгааны зардал 0,7 сая, Баянбулаг сумаас Магсарын хөшөөний засварын зардал 5,0 сая төгрөг нийт 23,2 сая төгрөг, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 41,0 мянган төгрөг буюу нийт 64,2 сая төгрөгийн зардлыг зарцуулж, 5546,5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 34 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 7 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 29 асуудлыг алдаа, зөрчилгүйд тооцлоо.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Аудитаар нийт 128045,6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2700,0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 2 зөрчилд 56128,5 мянган төгрөгийн албан шаардлага өгч 69217,1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө. Үүнд

2. Төсвийн төлөвлөлт гүйцэтгэлтэй холбоотой

Нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зарлагыг анхан шатны баримт, гэрээ, гүйцэтгэсэн ажлын тайлантай тулган шалгахад "Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар"-ын даргын 2019 оны 04 дүгээр сарын 20 ний өдрийн Орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх гэрээний дагуу хамтарсан багийн үйл ажиллагааны зардал 4500.0 мянган төгрөгийг Баянхонгор сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 2019.07.30 ний өдөр шилжүүлсэн байна. Тухайн зардлаас батлагдсан удирдамж, гэрээний дагуу 1147.0 мянган төгрөгийг зарцуулж 650.0 мянган төгрөгийг Ө.Тогтохбаярын эмчилгээний зардалд зарцуулсан байна.

Мөн 2700.0 мянган төгрөгийг багийн нийгмийн ажилтнуудын бичиг хэргийн зардалд зарцуулж тухай бичиг хэргийн материалыг хамтарсан багийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын гүйцэтгэлийг гаргаж хэрэгжилтийг тооцож ажиллаагүй. Дээрх гэрээний 3 дугаар зүйлийн 3.2-т "Дээрх чиглэлийн хүрээнд төлөвлөсөн үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж, гэрээний биелэлт болон санхүүгийн тайланг 2019 оны 4 дүгээр сарын 20, 10 дугаар сарын 30-ны дотор захиалагчид хүргүүлэн" гэсэн заалтыг зөрчиж гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж зардлыг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтууд, ГБХЗХГ-ын даргын Баянхонгор сумын Засаг даргатай байгуулсан "Орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх" гэрээ, хавсралтаар баталсан гэрээний санхүүжилтийн журмыг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

3. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

Тус байгууллагын авто тээврийн хэрэгслийн дансанд бүртгэлтэй албан ажлын зориулалтаар ашиглагдаж буй тээврийн хэрэгслээс 2018 онд 50800.0 мянган төгрөгөөр худалдаж авсан "Mitsubishi Lancer" 85-23 УБК, Nissan Advan 96-53 УНЧ, "Авто тулга трейд" ХХК MAZDA Familia 85-14 УНХ "Есөн шижир" ХХК Nissan Advan 21-25 ӨМҮ иргэн Б.Болдмаа, Alphard toyota 28-23 УБИ тус байгууллагын жолооч Ц.Ням-очир-ын нэр дээр бүртгэлтэй

бөгөөд тээврийн хэрэгслийн холбогдох бичиг баримт тухай байгууллагын эзэмшилд шилжүүлээгүй байна. Мөн 2017 оны 2495.0 мянган төгрөгийн "Yamaha" маркийн мотоцикл улсын дугаар аваагүй бичиг баримт байхгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь "Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна", Авто тээврийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т "Авто тээврийн хэрэгсэл өмчлөгч, эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага, иргэн дараах үүрэг хүлээнэ", 19.3.1 техникийн хяналтын үзлэг хийсэн гэрчилгээнд заасан хугацаанд авто тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт оруулах; 19.3.2-т "авто тээврийн хэрэгсэл бүрийн техникийн бичиг баримтын бүрдлийг хангах" гэсэн заалтыг тус тус зөрчиж "Эрх ба үүрэг" батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

4. Төсвийн төлөвлөлт гүйцэтгэлтэй холбоотой

Баянхонгор сумын ЗДТГ-ын дарга Ц.Насанбаяр 2018.10.17-ний өдрийн Б/136 тоот тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн 7 дугаар багийн нийгмийн ажилтан Б.Наранчимэгт Баянхонгор аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019.04.04. дугаар 111/ШШ2019/0007 дугаарт шийдвэрээр ажилгүй байсан хугацааны цалинг сумын ЗДТГ-ын даргын 2019.07.04 ний А/100 тоот тушаалаар 2506612 төгрөг, НДШ-д 256733 төгрөг цалингийн сангаас 2763386 төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас УТХ-зардалд 70200 төгрөг нийт 2833586 төгрөгийг олгосон байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

Аудитаар илэрсэн 69217,1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын явцад бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал, шатахууны зарцуулалт, кассаар болон нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрүүлэн зарцуулж буй орлого, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, малын данс бүртэл хөтлөлт, үндсэн болон эргэлтийн хөрөнгийн үлдэгдлийг гүйцээж мөшгин шалгаж тулган баталгаажуулах цаг хугацааны боломжгүйгээс үзээгүй болно.

2.13 Шилэн дансны мэдээлэл: Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар нь Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь байршуулж ажилласан бөгөөд байршуулаагүй мэдээлэл байхгүй

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуулаагүй
1	Бүтэн жил	11	11	11		
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	3	36	36		
5	Тухай бүр	8	96	96		

6	Нийт	27	151	151		
---	------	----	-----	-----	--	--

2.14 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

2.15 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

3.1.1 Илрүүлэлт:

Бүтэц орон тооны төлөвлөгөө гүйцэтгэлийг тулган шалгахад Сумын ЗДТГ-ын орон тоог 2019 оны төсөвт Шаргалжуут багаас гадна 60 орон тоотой ажиллуулахаар төлөвлөгөө баталсан байхад Сумын ЗДТГ-ын даргын 2019 оны 01 дүгээр тушаалаар 76, 2019.09.02 ний өдрийн А/120 тушаалаар 77 буюу орон тоог 11-ээр илүү баталж ажиллуулсан байна. Энэ нь тайланд онд 10 дугаар багийн төв шинээр байгуулагдсанаас 2 орон тоо шинээр нэмэгдсэн харин батлагдаагүй 9 албан тушаалыг шинээр бий болгож ажилтан ажиллуулсан Үүнд: Хэвлэл мэдээлэл гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн-1, нийтлэг үйлчилгээний тасгийн дарга-1, хот төлөвлөлт хариуцсан инженер-1, агаар хөрсний бохирдол хариуцсан ажилтан-1, газар зохион байгуулалт инженерийн шугам сүлжээ хариуцсан ажилтан-1, гэрэлтүүлэгч хариуцсан ажилтан-1, Засаг даргын туслах-1, БОХУБ-1, Эрүүл мэнд биеийн тамирын асуудал хариуцсан мэргэжилтэн-1 ажиллуулж төсвөөс 39091.7 мянган төгрөгийн цалин зардал гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.3 “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.9 “дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох”, эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох, ЗГ-ын 2009 оны 1 дүгээр сарын 14 ний өдрийн Сумын ЗДТГ-ын орон тооны хязгаар батлах тухай 13 дугаар тогтоолыг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл

Хууль, журам хэрэгжихгүй байх, төсвийн хөрөнгийг үргүй зарцуулах, төсвийн сахилга бат алдагдах.

3.1.3 Өгсөн зөвлөмж

Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хэрэгжүүлж, хууль, тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулах, батлагдсан орон тооны хязгаарыг мөрдөж ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

3.1.5 Зөвлөмжийн хэрэгжилтийг 2020 оны 04 дүгээр сарын 30 ний дотор Баянхонгор аймаг дахь төрийн аудитын байгууллагад албан бичгээр ирүүлэх.

3.2 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

3.2.1 Илрүүлэлт:

Тус байгууллагын программ хангамжийн дансанд 1920,0 мянган төгрөгийн нийт 5 программ бүртгэлтэй байна. Тухайн хөрөнгийг нэр төрлөөр нь авч үзэхэд 2006 онд хөрөнгийн бүртгэлд авсан 220,0 мянган төгрөгийн балансын өртөгтэй төрийн сангийн нэгтгэлийн "Plastik", 200.0 мянган төгрөгөөр 2010 онд худалдаж авсан архивын программууд ашиглалтгүй, элэгдлийн хугацаа дууссан 420,0 мянган төгрөгийн программ байна.

Энэ нь Төрийн болон орон өмчийн тухай хууль 31 дүгээр зүйлийн 1."Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.1.2 Эрсдэл

Ашиглалтгүй биет бус хөрөнгийг нягтлан бүртгэл, тайлангаас хасаагүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу ашиглалтгүй байгаа программ хангаж судалж холбогдох журмын дагуу шийдвэрлэх

3.1.2 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

3.3 Төсөв гүйцэтгэл:

3.3.2 Илрүүлэлт:

Тайлант онд шатахууны зардалд 23640.0 мянган төгрөг батлагдсанаас шатахууны зардалд 27640.0 мянга, мөн нэмэлт санхүүжилтийн дансанд орсон оготно устгалын зардлаас 2400.0 мянга, ЗД-нөөц хөрөнгийн зардлаас 1600.0 мянган төгрөгийг мал тооллогын зардалд тус тус зарцуулсан байна. Дээрх зардлыг нярав, нягтлан бодогч нар түлш шатах тослох материалын тайланд орлого авахдаа нэг бүрийн үнэ, нэр төрлөөр орлого аваагүй зөвхөн шатахуун олголтын бичгийн дүнгээр өөрөөр хэлбэл Нийлүүлэгч ААНБ-н нэрээр орлого авч шатахуун зарцуулсан албан тушаалтны нэрээр зарлага гаргаж тайлагнасан байна.

